



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑1 оны 1᠐ сарын ᠑7 өдөр

Дугаар А/᠕᠐᠑

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон шинэ хаяг авсан 13 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 887, 959 дэх хэсэг, 2008 оны 119 дүгээр захирамжийн хавсралтын 67 дахь хэсэг, 2010 оны А/435 дугаар захирамжийн хавсралтын 10 дугаар хэсэг, 2017 оны А/422 дугаар захирамжийн хавсралтын 248 дахь хэсэг, 2018 оны А/159 дүгээр захирамжийн хавсралтын 97 дахь хэсэг, 2018 оны А/218 дугаар захирамжийн хавсралтын 248 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

48121᠐529